



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 51/421

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр  
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цогсүрэн овогтой **Ивээлийг** АНУ-ын Массачусеттийн их сургуулийн бакалаврын сургалтад цахилгаан инженерийн чиглэлээр 4 жил, **Доржпүрэв** овогтой **Болдыг** АНУ-ын Пеннсилванийн Улсын их сургуулийн бакалаврын сургалтад инженерийн чиглэлээр 4 жил, **Лхагважав** овогтой **Энхжаргалыг** АНУ-ын Мичиганы их сургуулийн бакалаврын сургалтад математикийн чиглэлээр 4 жил, **Хорлоо** овогтой **Мичидмааг** Хонконгын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтад хими, химийн инженерийн чиглэлээр 4 жил, **Болд** овогтой **Мягмаржавыг** АНУ-ын Аустин дахь Техасын их сургуулийн бакалаврын сургалтад цахилгааны инженерийн чиглэлээр 4 жил, **Золбаяр** овогтой **Болор-Эрдэнийг** Пеннсилванийн Улсын их сургуулийн бакалаврын сургалтад инженерийн чиглэлээр 4 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБЯАР